

ГАРЧИГ

Д.д		Хуудасны дугаар
1	Ордын ерөнхий мэдээлэл	2
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	7
3	Байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд	10
4	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	11
5	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	12
6	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	12
7	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	12
8	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	13
9	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	13
10	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	13
11	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт	14
12	Дүгнэлт	16

1. Газарзүйн байршил

Бөхөгийн хөндийн орд нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт “Очирням” ХХК-ийн эзэмшиж буй 12215А тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 1:100 000-ны масштабтай байр зүйн зургийн L-48-10 тоот хавтгайд хамрагдах цэгүүдээр хязгаарлагдсан 52 гектар талбайг хамран, Улаанбаатар хотоос урагш 35 км зайд, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг Шувуун фабрикаас урагш 1.3 км-т оршино.

Хүснэгт №1

Цэгийн дугаар	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	106	34	50	47	44	46
2	106	35	15	47	44	46
3	106	35	15	47	44	26
4	106	35	10	47	44	26
5	106	35	10	47	44	10
6	106	34	50	47	44	10

2. Физик газарзүй, байгаль, цаг уурын нөхцөл


Газарзүйн байрлалын хувьд Хэнтийн уулархаг мужийн өмнөд хэсэгт Бөхөг голын хөндийд харъяалагдана. Судалгааны талбай орчмын уулсын харьцангуй өндөр 1300-1500м, хөндийн туйлын өндөржилт нийт талбайн хэсэгт 1225.98-1230.69 м байна. Талбайн гадаргуугийн талбайн рельеф нь бараг тэгшивтэр, голын урсгалын дагуу зүүн урдаас баруун хойш ургаш чиглэсэн доош суусан маягын гадаргуу үүсгэжээ.

Усан сүлжээний хувьд ордын орчимд Туул, Бөхөгийн голуудтай. Талбайн дундуур Бөхөгийн гол дайран өнгөрдөг ба тогтмол урсацгүй, тухайн жилийн хур хундасны хэмжээнээс шалтгаалан урсдаг байна.

Уур амьсгалын хувьд эх газрын эрс тэс уур амьсгалтай, хур дундас багатай хуурай агаартай, цаг агаарын олон жилийн ажиглалтын дунджаар хамгийн хүйтэн 12-1-р сард болдог ба -25-30⁰С хэм, хамгийн халуун үе 6-8-р сард болдог бөгөөд +25+30⁰С хэм байдаг. Жилийн дундаж хур хундасны хэмжээ 200-250 мм ба үүний дийлэнх (150-

**“Бөхөг солонго” элс хайрганы уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

180мм) нь 6-9сард бороо хэлбэрээр буудаг байна. Талбайн орчимд олон жилийн цэвдэгшлийн бүс тааралддаггүй. Салхий гол төлөв баруун хойноос зүүн ургаш чиглэлтэй, са Тэр бум мод төслийн хүрээнд лхины жилийн дундаж хурд 4.7м/сек гэх боловч хавартаа 10-15 м/сек хүрэх тохиолдолд элбэг. Шимт хөрсний зузаан 10-20 см, зарим тохиолдолд 40 см хүрдэг. Шар хүрэн, элсэрхэг хөрстэй. Ургамалын бүрхэвч сийрэг, тааруу, голдуу хээрийн бүсийн ургамал ургадаг. Ан амьтадаас үнэг, хярс, чоно, уулархаг хэсэгтээ таварга тааралдана.



Бөхөгийн хөндийн ордын байршлын зураг

2004 онд 6929Х хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий Бөхөг-солонго нэртэй хайгуулын талбайд “Солонго бил” ХХК нарийвчилсан хайгуулын ажил гүйцэтгэж,

нөөцийн тайланг Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн 2008 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 28-04 тоот хуралдаанаар хэлэлцүүлж, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын даргын 2008 оны 08 дугаар сарын 416 тоот тушаалаар ордын 1173.4 мянган м³ элс-хайрганы нөөцийг ашигт малтмалын улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн.

3. Бөхөгийн хөндийн элс-хайрганы ордын геологийн тогтоц

Ордын тогтоц

Бөхөгийн хөндийн ордын элс-хайрганы хольц нь өмнө нь 1986 онд тогтоогдож эрэл үнэлгээний ажлаар тодорхой хэмжээнд судлагдсан. /Геологич Ж.Цэрэндорж/ Бөхөг-Солонгын орд нь Бөхөг голын элс-хайрганы хольцын үргэлжлэл юм. Талбайд тархсан хэмхдэс чулуулгийн зузаалаг нь аллювийн голдрил, сайраас тогтох ба энэ нь нэг төрлийн элсэрхэг-хайргархаг-хайрган материалаас бүрдэнэ. Эдгээр материал нь ерөнхийдөө саарал, шаравтар-саарал өнгөтэй байна. Элс хайрганы чулуулагт элсний агуулга 35.5 %, 5-40 мм-ийн хэмжээтэй хайрга 64.7%, 70 мм-ээс том хэмжээний валун 0.16% буюу бараг байхгүй.

Бүдүүн хэмхдэст материалын хэлбэр нь дугуйрсан сайн мөлгөржсөн, гадаргуу нь толигор байна. Петрографийн найрлагаараа том ба бүдүүн хэмхдэст материал нь голлон метаморфичлогдсон элсэн чулуу, бялхмал бөсөл чулуулаг түүнчлэн филлитлэгдсэн занар, алеврит-цахиурлаг-шаварлаг занар, боржин ба түүний дресва, маш багаар микродиорит, диорит-порфирит, хүчиллэг найрлагатай бялхмал чулуулгаас тогтсон хайргаас бүрдэнэ. Хайрганцар, хайрга болон жижиг валун нь ихэнхдээ бат бэх, нягт, хатуу байна. Бүдүүн хэмхдэст материалын хэмжээнд хэврэг бө өгөршсөн чулуулгийн мөхлөг дунджаар 5-7%, лабораторийн судалгаагаар хэврэг чулуулгийн мөхлөгийн агуулга 5-20 мм-ийн хайрганд 13.25%, 20-40 мм хайрганд 12.7% байна.

Хэврэг болон өгөршсөн чулуулгийн мөхлөг гол төлөв хувиралд орсон аркоз элсэн чулуу, заримдаа витрокластик туф, зарим тохиолдолд филлитчилэгдсэн алеврит шаварлаг занарт илэрнэ. Мөхлөгийн хэлбэр нь дугуйрсан мөш ховроор өнцөглөсөн, мөхлөгийн мөлгөржилт сайн, гадаргуу нь толигор байна.

Хайрга, хайрганцар нь петрографийн найрлага болон хэврэг чулуулгийн мөхлөгийн агуулга түүнчлэн мөхлөгийн хэлбэр нь мөөгөржилт элэгдэлт нь хайгуулын талбайн хэмжээнд, мөн гүн рүүгээ өөрчлөлтгүй болно.

Бүдүүн хэмхдэст материалд хавтгайлаг, үзүүрлэг хэсгийн мөхлөгийн агуулга 13.8-19.3% хүртэл хэлбэлзэнэ.

Элс-хайрганы хольцын 2.5 мм-ээс бага хэсгийг /элсийг/ лабораторын нөхцөлд шинжлүүлэн судалгаа хийлгэхэд элсний мөхлөг нь мөлгөржилт сайтай, бэржгэр гадаргуутай. Шигшсэн элс нь ерөнхийдөө дунд том ширхэгтэй, элсний ширхэгийн модуль 2.5-3.81, дунджаар 3.08 байна. Эндээс үзэхэд ордын хэмжээнд элс нь том ширхэгтэй байна. Элс нь өөрийн жингээрээ шавар, наангилаг шавар, тоосорхог хольц болон органик хольцоос амархан ялгарч байна.

Органик хольц нь этолоноос цайвар байгаа нь шаардлагын хэмжээнд байгааг харуулж байна. Элсэнд гялтагануур, карбонатлаг, кальцитлаг эрдсийн хольц байхгүй. Элсэн дэхь шаварлаг тоосорхог хэсгийн агуулга 0.56-2.35%, дунджаар 1.28% байсан.

Хайгуул хийсэн талбайн хэмжээнд элс-хайрганы хольцын зузаан нь 4.4-4.9 м, дунджаар 4.64 м байв. Элс- хайрганы хольцын чанар талбайн төрхөлт болон гүндээ жигд байна.

Элс хайрганы хольцын ашигт зузаалаг гадаргуугаас хуулга хөрсний зузаан ба хөрс ургамлын үеийн доор 0.1-0.6 м-т давхарга, хэвтэш маягийн хэвтээ байрлалтай тогтоцтой болно. Хайгуул хийсэн талбайн хэсэгт 5м хүртэл гүн шуфт нэвтрэлт хийхэд хөрсний ус тааралдаагүй тул элс-хайрганы хольцын нөөцийг тооцоолохдоо устай давхарга гэж ялгаагүй, зөвхөн усгүй давхаргаар нөөцийг тооцоолсон байна.

4. Нөөцийн тооцооны үр дүн

Ордын талбайн хэмжээ 25.3 га, ашигт давхаргын дундаж зузаан 4.60 м, хучаас хурдасны дундаж зузаан 0.47 м, элсний нөөц баттай (А), бодитой (В) зэргээр 414283.9 м³, хайрганы нөөц баттай (А), бодитой (В) зэргээр 759148.9 м³, нийт элс-хайрганы нөөц 1173433 м³, хучаас хурдасны эзэлхүүн 114027 м³, хөрс хуулалтын итгэлцүүр 1/10 байна.

Бөхөгийн хөндийн элс-хайрганы ордын нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

Хүснэгт №2

Нөөцийн зэрэг, блокын дугаар	Ашигт давхаргын зузаан /м/		Талбай н хэмжээ /м2/	Эзэлхүүн /м3/		Нөөц дэх хэсгүүдийн агуулга /%/		Ашигт малтмалын нөөцийн хэмжээ /м3/	
	хөрс	элс		хөрс	элс	элс	хайрга	элс	хайрга
С-1	0.4	4.6	12782	5113	58797	35.81	64.19	21055.3	37741.9
С-2	0.34	4.71	59900	20366	282129	35.17	64.83	99224.8	182904.2
В-3	0.28	4.77	44000	12320	209880	34.84	65.16	73122.2	136757.8
В-4	0.49	4.69	42700	20923	200263	35.21	64.79	70512.6	129750.4
С-5	0.67	4.51	57440	38485	259054	35.47	64.53	91886.6	167167.8
В-6	0.3	4.7	24000	7200	112800	36.98	63.02	41713.4	71086.6
С-7	0.8	4.2	12026	9621	50509	33.20	66.80	16769.1	33740.1
Дүн			252848	114027	1173433	35.24	64.76	414283.9	759148.9
Дундаж	0.47	4.60							

5. 2024 онд хийсэн нөхөн сэргээлт ажил

5.1. Биологийн нөхөн сэргээлт

Биологийн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа нь техникийн үе шат бүрэн дуусаж, овоолгын болон талбайн хөрс чулуулаг тогтворжиж, нягтарсны дараа овоолгод хадгалж байсан шимт хөрсийг эргүүлэн байршуулах замаар биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийдэг.

Ногоон байгууламжыг нэмэгдүүлэх, тоосжилт бууруулах үүднээс байгаль орчны нарийвчилсан үнэлгээ болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаснаар өмнө жилүүдэд техникийн нөхөн сэргээлт хийж дууссан 15000м² буюу 1.5 га талбайд 1550 ширхэг мод тарьсан. Мод тарих ажиллах хүч, усалгаа, арчилгаанд нийт 2750.0 мян.төгрөг зарцуулсан.

5.2 Техникийн нөхөн сэргээлт

“Ашигт малтмалын тухай” хуулиар хүлээсэн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийн дагуу нөхөн сэргээлтийн ажлыг жил бүрийн ажлын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байна.

2024 онд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 4 ажилтан, 1 ачигч, 1 эксковатор, 1 бульдозер, 1 өөрөө буулгагч HOWO маркын автомашинаар 1.0 га талбайд дээр дурьдсан хэлбэрээр гүйцэтгэлээ. Ачигч болон бульдозер ашиглан эвдэрсэн талбайг түрж хэвгийжүүлэх, хэлбэржүүлэх ажлыг, нөхөн дүүргэлтийг автомашинаар зөөж тээвэрлэлээ.

Нөхөн сэргээлтийг өөрийн нөөц бололцоо машин техник, хүн хүчид тулгуурлан ашиглалт, олборлолтын явцад үүссэн дотоод болон гадаад овоолго, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарсан хаягдал чулуулгыг ашиглан нөхөн дүүргэлт хийх, тэгшлэх, шимт хөрсөөр хучиж биологийн нөхөн сэргээлтэд бэлтгэх, налуулах, хэвгийжүүлэх гэх мэт хэлбэрээр хийж хүрээлэн байгаа орчин, хүн малд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр засаж тохижууллаа.

Хөрс хуулалттай холбоотой үүссэн овон товон гадаргууг ерөнхийд нь сийрүүлэн тэгшлэх, налуу гадаргууг орчных нь гадаргуутай ойртуулан хэлбэршүүлэх, ажиллагаанууд хийгдэж, дараа нь нарийвчлан хэлбэржүүлж, өнгөлөн тэгшлэх ажиллагааг гүйцэтгэлээ.

Нөхөн сэргээлтийн стандартад заасны дагуу хэлбэржүүлэхдээ орчны газрын тогтоцыг харгалзан ойролцоох газрын хэлбэрт аль болох ойртуулан налуугийн өнцгийг үүсгэхийг хичээсэн.

Нөхөн сэргээлтийг:

- Ашиглагдсан орон зайг нөхөн дүүргэх;
- Ашиглагдсан орон зай, ухшийг хэвгийжүүлэх, хэлбэршүүлэх;
- Эвдэрсэн газрыг болон овоолгыг тэгшлэх, гадаргууг нь хэлбэржүүлэн тэгшлэх;
- Овоолгын хажууг хэвгийжүүлэн дэвсэгжүүлэх;
- Тэгшилсэн талбайг нягтаршуулах зэрэг хэлбэрээр хийлээ.

Ачигч ашиглан эвдэрсэн талбайг түрж хэвгийжүүлэх, хэлбэржүүлэх ажлыг, нөхөн дүүргэлтийг автомашинаар зөөж тээвэрлэлээ.

**“Бөхөг солонго” элс хайрганы уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

А. Техникийн нөхөн сэргээлтийн шууд зардал: Хүснэгт №3

Д/д	Зардлын нэр	Дүн /мян.төгрөг/
1	Түлш, тослох материалын зардал	10500.0
2	Цалингын зардал	3550.0
	Нийт нөхөн сэргээлтийн шууд зардлын дүн	14050.0

Б. Техникийн нөхөн сэргээлтийн нэмэлт зардал:

Хүснэгт №4

Д/д	Зардлын нэр	Дүн /мян.төгрөг/
1	Хөдөлмөр хамгааллын хувцас	393.58
2	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	330.0
3	Хоолны зардал	523.49
	Нийт нэмэлт зардлын дүн	1247.07
	НИЙТ ЗАРДАЛ	15297.07

Мөн техникийн нөхөн сэргээлт хийхэд шаардагдах зардлын тооцоог Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын хамтарсан 2010 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А-132/112 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх ажлын зардлын үнэлгээ тооцох аргачлал”-ын дагуу тооцон гаргалаа.

“Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, нэр томъёо тодорхойлолт MNS 5914:2008” стандартад нэр томъёо тодорхойлолтыг заасан.

Зарим нэр томъёоны тайлбар

Хүснэгт №5

д/д	Нэр томъёо	Тайлбар
	Газрын эвдрэл	Ашигт малтмал олборлох, геологи-хайгуулын ажил гүйцэтгэх, судалгаа хийх, барилга байгууламж барьж байгуулах, хөрсөн бүрхэвчийн эвдрэл үүсгэхүйц бусад төрлийн ажил гүйцэтгэх, тэрчилэн тухайн орчны гидрологийн горим алдагдах, үүсмэл гадаргуу үүсгэх зэргээр газрын төлөв байдлын бусад шинж чанар өөрчлөгдөх үйл явц
	Эвдэрсэн газар	Эвдрэлийн улмаас аж ахуйн анхдагч үнэ цэнээ алдаж, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх эх үүсвэр болж хувирсан газар

**“Бөхөг солонго” элс хайрганы уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

	Газрын нөхөн сэргээлт	Эвдэрсэн газрын аж ахуйн үнэ цэнэ, бүтээмжийг нь сэргээх, тэрчлэн хүрээлэн буй орчны нөхцөлийг нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээ
	Газрын нөхөн сэргээлтийн техникийн үе шат	Эвдэрсэн газрыг цаашид аж ахуйн тодорхой зориулалтаар ашиглах зорилгоор бэлтгэл байдлаар нөхөн сэргээх үе шат. Тайлбар: Нөхөн сэргээлтийн техникийн үе шатанд дүүргэлт, булшлалт, тэгшлэлт, хажуу налууугийн хэлбэршүүлэлт, хөрс хуулалт, хуулсан хөрс ба үржил шимт чулуулгийг нөхөн сэргээж буй газарт тээвэрлэн хүргэж хучилт хийх, шаардлагатай тохиолдолд усалгаа хийх, зам болон тусгай зориулалтын гидротехникийн зэрэг ажил багтана.
	Хажууг налуулан засах	Ил уурхайн ухашны хажуу болон овоолгын хажуугийн налууугийн өнцгийг багасгах зорилгоор хийх газар шорооны ажил
	Овоолгыг хэлбэршүүлэх	Дараа нь ашиглахад таатай нөхцөл бүрдүүлэх зорилгоор овоолгын хэлбэрийг өөрчлөх

Стандартад зааснаар сэвсгэр хурдас, зөөлөн чулуулагтай 15м хүртэл гүнтэй ил уурхайн эвдрэлд орсон газрыг тухайн газрын анхны төлөв байдалд ойртуулан тэгшилж ургамалжуулах ба хажуу ханын налуу 18⁰-аас ихгүй байхаар заасан.

Уул уурхайн төслийн хүрэлэн буй орчны асуудал нь төслийн техник-эдийн засгийн үндэслэлийн чухал бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд уг төслийг хүрээлэн буй орчинд нөлөөлөлх нөлөөллийг багасгах, холбогдох стандартуудад нийцүүлэх, уурхайн үйл ажиллагаа ба уурхайн хаалтын явцад төлөвлөгдөөгүйгээр үүсэн гарах ашиглалтын болон капитал зардлын улмаас үүсэх санхүүгийн эрсдэлийг бууруулах замаар хүрээлэн буй орчны нөлөөллийг бууруулах чиглэлийг тодорхойлж энэхүү баримт бичигт тусгасан болно.

Байгаль орчинд учирч болзошгүй нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусган боловсруулж Байгаль орчны яамаар батлуулж ажилласан.

6. Байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд

Одоогийн байдлаар төслийн техник эдийн засгийн үндэслэлд төслийн улмаас хүрээлэн буй орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийн боломжийн хэмжээнд урьдчилан тооцоолж, аль болох бага хэмжээнд байлгах, урьдчилан сэргийлэхийн тулд дараах зүйлсийг тусгалаа. Үүнд:

- Орд нь хөрс хуулалт харьцангуй багатай ордод хамаарах тул хөрсний овоолгод харьцангуй бага талбай шаардагдах бөгөөд төслийн шийдэлд ашиглалтын жилүүд дэх уулын ажлыг хэд хэдэн хувилбараар нарийвчлан төлөвлөсөн.
- Уурхайн үйл ажиллагааны төлөвлөгөөг хийхдээ гадаад овоолгод дарагдах талбайг боломжит хамгийн бага байлгах зорилтод тулгуурлсан бөгөөд ашиглалтын жилүүдэд ашигласан талбай, овоолгуудыг хэлбэржүүлэн техникийн нөхөн сэргээлтийн ажлуудыг хийж эхэлсэн.
- Ашиглалтын явцад зөвхөн технологийн процессуудад зайлшгүй шаардлагатай замуудыг байгуулан, чиглэлийг тогтоож, тоног төхөөрөмжүүдийг парклах талбайг тусгайлан байгуулж, онц шаардлагагүй зам гаргаж газрын гадарга эвдлэгдэхээс чанд сэргийлнэ.

Хог хаягдлын хяналт, удирдлага, зохион байгуулалтын хувьд энэ үйл ажиллагааг оновчтой шийдэх зорилгоор тусгайлан журам боловсруулж мөрдүүлнэ. Уг зорилтын хүрээнд байгаль орчин болон хог хаягдлын талаархи хууль, тогтоомж, дүрэм, журмуудын дагуу олон улсын стандартын шаардлагаад нийцсэн арга технологийг хэрэгжүүлнэ.

Урьдчилан төлөвлөж байгаагаар ордыг ашиглахад хатуу хог, хаягдал гарахгүй гэж тооцож байгаа ба ажиллагсадаас үүдэлтэй хог хаягдлыг нэгдсэн журмаар зайлуулна. Тоног төхөөрөмжийн эвдэрсэн эд ангиудыг цаашид ашиглахгүй тохиолдолд тусгайлан бэлтгэсэн талбайд цуглуулж, дараа нь уурхайн ашиглагдсан орон зайд булаах боломжтой гэж үзэж байна.

Химийн хорт бодисын хувьд ордыг ашиглахад химийн хорт бодис ашиглахгүй тул энэ төрлийн хог хаягдал гарахгүй.

7. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Элс хайрга олборлох төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд дурдсанаар газрын хэвлийг эвдэж өнгөн хөрс хуулах, карьер нээх, овоолго хийх, олборлох, тээвэрлэх, буталж ангилан ялгаж үйл ажиллагаагаар байгаль дэлхий эвдэрч бохирдохоос гадна тоос гэх мэт агаарт дэгдэх, шатах, материал болон шингэн хаягдал хөрсөнд нэвчих замаар бохирдол үүсч эко системд их бага болон болзошгүй сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Бохирдлын эх үүсвэр нь шороон авто зам, түлш шатахуун агуулах, бохирын цэг, хатуу хог хаягдал, ахуйн химийн бодис зэрэг болно.

Элс хайрганы ордын мөргөцөг дотор элс хайрга олборлож тээвэрлэх үед техникийн буруу үйл ажиллагаанаас болж сөрөг нөлөөллүүд үүсч бий болдог. Үүнд уурхайн мөргөцөг дотор элс хайрга олборлож тээврийн хэрэгсэлд ачих үед хуурай шороо хийсч агаар орчныг бохирдуулж хүний эрүүл мэндэд сөрөгөөр нөлөөлж болзошгүй юм. Үүнийг бууруулахын тулд 2024 онд дараах арга хэмжээнүүдийг авч ажилласан болно. Үүнд

- 1.. Эксковатор болон ачигч мөргөцөг дотор элс хайрга олборлож байгаа /хуурайшилтын/ үед услаж талбайг чийгшүүлэх замаар тоосжилтын хэмжээг бууруулах арга хэмжээ авч ажилласан.
2. Бульдозер болон ачигчаар уурхай хүртэлх замыг өдөрт нэг удаа хусч замын дэд хэсгийн хуурай сул шороог цэвэрлэж тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр үүсэх тоосжилтийг бууруулж ажилласан.
3. Олон салаа зам гаргуулахгүй байх арга хэмжээ авч уурхайгаас Тэрэлж явах төв зам хүртэл сайжруулсан шороон замыг тавьсан.
4. Хүнд машин механизм болон тээврийн хэрэгслүүдийн яндангаас гарах хорт хий / CO_2 , NO_2 , SO_2 / стандартын хэмжээнд байгаа эсэхийг жилд нэг удаа техникийн үзлэгт бүрэн хамруулж шаардлага хангаагүй техникийг ажиллуулахгүй байх арга хэмжээ авч ажиллаж байна.

7.1 Хог хаягдлын нөлөөлөлийг бууруулах арга хэмжээ

Ахуйн хаягдал болон үйлдвэрээс гарах бохир усыг хяналтгүй хаясны улмаас орчны хөрс, газрын доорхи ус, ургамалжилтанд дам нөлөөлдөг тул, аль болох бага хог хаягдал үүсгэх, дахин ашиглах эсвэл дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулах, үлдсэн хог хаягдлыг байгаль орчинд аюулгүй арга технологиор устгах зарчмыг баримтлан “Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлж байна

7.2 Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Элс хайрга олборлолтын үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, тээвэрлэлт, ил задгай хөрснөөс хийссэн тоос нь орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болдог тул хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд агаарт дэгдэх тоосны хэмжээ харьцангуй ихсэдэг учир хуурайшилт ихтэй улиралд зам талбайг тогтмол усаар услан зөвхөн зөвшөөрөгдсөн замаар тээвэрлэлт явуулсан.

Усалгаа хийж буй явцыг зурагт үзүүлэв .



Уурхайд ашиглагдаж буй хүнд машин механизмаас ялгарах утаа хий нь агаарын бохирдлын эх үүсвэр болдог тул техникийн үзлэгт оруулсан, ялгаруулж буй хорт утаа нь стандартын түвшинд буй машин техникийг ашиглах, ашиглагдаж буй машин

“Бөхөг солонго” элс хайрганы уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

техникт үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийх, яндан бүрт шүүлтүүр суурилуулж өгөх, тохиргоо техникийн горимыг сайтар мөрдөх, түлшний найрлага, чанар, стандартыг сайтар хянах, чанартай түлш хэрэглэх зэрэг арга хэмжээ авч ажилласан.

7.3 Хөрсний эвдрэл, элэгдэлд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Үржил шимт хөрсийг хуулан овоолго үүсгэн технологийн дагуу хадгалж, нөхөн сэргээлтэнд эргүүлэн ашиглаж эргэлтэнд оруулж байна. Хөрсний элэгдэл, эвдрэлийг нэмэгдүүлэхгүйн тулд зөвхөн зөвшөөрөгдсөн замаар тээвэрлэлт явуулна. Шатах, тослох материалыг хөрсөнд нэвчихээс сэргийлж, тэгшилсэн бетонон талбай болон гражид машин техникийн үйлчилгээг хийдэг.

Хүрээлэн буй орчны хөрсний чанарт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Хүснэгт 6

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжиж байгаа, Төлөвлөж байгаа/	Хэрэгжилт
1	Тээвэрлэлтийн замын дагуу олон салаа зам бий болох	Тээвэрлэлтийг зориулалтын замын дагуу явахад хяналт тавих	Уурхайгаас тосгон хүртэл	Тогтмол хэрэгжиж байгаа.	Уурхайн орчин болон бусад үйл ажиллагаа явагдаж буй газарт хяналт тавьж ажиллаж байна. 2024 онд зөрчилгүй ажилласан.
2	Засвар үйлчилгээний явцад асгаралт гарч хөрс бохирдох	Техникүүдэд хяналт тавих, асгаралтаас сэргийлэх, зориулалтын талбайд засвар үйлчилгээг хийлгэх, хяналт тавих	Техникүүдэд	Тогтмол хэрэгжиж байгаа.	2024 онд асгаралт гаргасан зөрчил байхгүй. Зориулалтын засварын газарт үйлчилгээгээ хийлгэж байна.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ : Төсөвт өртөг **1500.0** мян.төг болсон.

8. 2024 оны байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 7

№	Хийгдэх ажлууд	Зардал, мян.төг		тайлбар
1	Ахуйн шингэн хаягдлыг тусгайлан доторлосон нүхэнд хуримтлуулан битүүмжлэх, ариутгал, устгал хийх	500.0		Бүгд биелсэн Ариутгал 2 удаа хийгдсэн
2	Хөрсийг ямар нэг химийн бодисоор бохирдуулах, шатах тослох материалыг ил задгай асгахыг хориглох			Энэ ажил хэвшсэн
3	Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг эмх цэгцтэй төвлөрүүлэх нэг цэг байгуулах	200.0		Энэ ажил хийгдэж хэвшсэн
4	Машин техникийн үйлчилгээ, засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	-		Энэ ажил хийгдэж хэвшсэн

“Бөхөг солонго” элс хайрганы уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

5	Төв зам болон орд хүрэх зам дагуу, ордын талбай, үйлдвэр орчимд замыг тэмдэгжүүлэх	-	Энэ ажил хийгдсэн
6	Гал түймэр гарахаас сэргийлэх арга хэмжээг авч, түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, булан цэгүүд бэлтгэсэн байх.		-
7	Элс хайрга олборлох, тээвэрлэх ажлыг геологи, уул техникийн нөхцөл, зураг төслийн дагуу хийх	-	Уулын ажлын төлөвлөгөөний дагуу хийсэн
8	Уурхай орчмын замын тоосыг усалгаа хийж бууруулах		Төлөвлөгөөний дагуу хийдэг
	дүн	700.0	Бүгд биелсэн

9. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

9.1 Энэхүү ажлын хүрээнд ХУД-ийн 13-хорооны Шувуун фабрикын айлуудын үерийн улмаас эвдэрч машин, хүн явахад хүндрэлтэй болсон гудамжуудад элс хайрга буулган, дүүргэж тэгшилж өгсөн.

Айлын хашааны хажууд овоорсон талбайг тэгшилж янзалсан. 3 өдөр 2 ковштой ажилласан.

Бохир шороо 12 машин $20\text{м}^3 = 240\text{м}^3$ нэгж үнэ 24.0мян.төг = 5760.0 мян.төг

Ковш 3 өдөр $360\text{л} * 2770 = 997.2$ мян.төг

Ковш 2 өдөр $240\text{л} * 2770 = 664.8$ иян.төг

Тээврийн хөлс 12 машин $20\text{м}^3 = 240 * 10000 = 2400.0$ мян.төг

Бүгд зардал 9822.0мян.төг

9.2 УБ хотын ХУД-ийн Шувуун фабрикын 60 жилийн ойд зориулж 3.0 сая төгрөг бусад хандивт 2.0 сая нийт 5.0 сая төгрөгийн хандив өгсөн.

Нийт зардал 14822.0 мян.төг

10. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Манай уурхайн хүрээнд хамааралгүй. Учир нь уурхайн объектоос хамгийн багадаа 2 км-ийн радиуст суурьшлын бүс нутаг байхгүй.

11. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Манай уурхайн хүрээнд хамааралгүй. Уурхайн ойролцоо археологи, палентологийн олдвор одоогийн байдлаар илрээгүй. Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно

12. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Манай уурхайн хүрээнд хамааралгүй. Учир нь уурхайд химийн бодис хэрэглэдэггүй

13. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хог, хаягдлын менежментийг хэрэгжүүлэхдээ Хог хаягдлын тухай хууль , Хог хаягдлыг ангиллан ялгаж хаях журам, MNS5344:2011 ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага зэргийг мөрдөн ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Холбогдох төрийн байгууллагатай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулан ажиллаж байгаа.
- Хог хаягдлын цэгийг зохих стандартын шаардлагад нийцүүлэн байгуулсан.
- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, төрөлжүүлэн хаяж хэвшсэн. Хог хаягдлын хэмжээг хамгийн бага байлгах, үүссэн хог хаягдлыг дахин ашиглах, зарим дахин боловсруулах боломжтой хаягдлыг хоёрдогч түүхий эд авах цэгт тушаах зэргээр хог хаягдлын хэмжээг бууруулж ажилласан. Үүнд: Мод, цаас зэрэг шатах хаягдлыг ялгаж тусад нь цуглуулан уурхайн ажилчдын тосгоны халаалтад ашигласан. Хаягдал төмөр болон хуванцар сав, гялгар уут, пластик хаягдлыг ангилан ялгаж цуглуулан Улаанбаатар хотод байрлах хоёрдогч түүхий эд авдаг газруудад нийлүүлэв.
- Хог хаягдлын цэгт тогтмол ариутгал хийж хог хаягдлаас үүдэлтэй орчны бохирдол үүсгэхгүй байх тал дээр анхааран ажилласан.
- Хог хаягдлыг Биокомбинатын төвлөрсөн хогийн цэгт тогтмол зайлуулж хур хог үүсгэхээс сэргийлж байна.

Хог хаягдлын төлбөрийг цаг тухай бүрт төлж барагдуулсан.

Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн зардал **600.0** мян.төг зарцуулсан

Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт №8

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, төгрөг	Тоо хэмжээ	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлсэн хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Ахуйн	Ахуйн гаралтай хог хаягдлыг ангилан ялгаж зориулалтын цэгт хүргэх	Үйлдвэрийн бүх төрлийн байгууламжууд	Улиралд 1 удаа	10,0	2	200,0	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлын тухай хууль
Үйлдвэрийн	Үйлдвэрлэлийн гаралтай хаягдлыг ил задгай хаяхгүй зориулалтын битүү саванд ангилан ялгах түүхий эд боловсруулах цэгт нийлүүлэх арга хэмжээнүүдийг авах	Үйлдвэрийн бүх төрлийн байгууламжууд	Улиралд 1 удаа	100,0	2	200,0	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлын тухай хууль
Аюултай	Аюултай хог хаягдлыг кодлон ялгаж бүртгэлжүүлэх, стандартын дагуу байгуулсан агуулахад хадгалах, 2 дахь түүхий эд авдаг үйлдвэрт нийлүүлэх	Үйлдвэрийн бүх төрлийн байгууламжууд	Улиралд 1 удаа	75,0	4	200,0	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлын тухай хууль Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
Нэг жилийн зардал						600,0		

“Бөхөг солонго” элс хайрганы ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл”-ийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн зардал **600.0** мян.төг болж зарцуулсан.

14. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчныг хамгаалж, нөхөн сэргээхэд ордыг ашиглах төслийн ТЭЗҮ, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, нөхөн сэргээх төсөл, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу ажилласан.

- Уурхайн хүчин чадал бага тул удирдлагын нүсэр бүтэц байх шаардлагагүй юм. Иймд байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг компаний захирал уурхайн дарга, инженерүүд хариуцан гүйцэтгэх бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар ажиллав.
- Компаний удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль журмын дагуу уурхайн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ.

Удирдлага зохион байгуулалтын зардал

Хүснэгт №9

№	Хийгдэх ажлууд	Зардал, мян.төг	тайлбар
1	Байгаль орчныг хамгаалах, ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалтыг өөрийн ажиллагсдын дунд зохион байгуулах.	300.0	биелсэн
2	Уурхайн ажилчид мөн ачигчидыг тусгай амны хошуувчаар хангасан.	350.0	Зардал гараагүй
3	Ой, хээрийн түймрээс сэргийлэх, унтраах хэрэгслээр бүрэн хангах, ажиллагсдыг түймэр унтраах арга барилд сургах, гал түймэр гарсан тохиолдолд шуурхай унтраах арга хэмжээ авах. Байгаль хамгаалагчдад туслах.	-	Зардал гараагүй
	дүн	650.0	

**“Бөхөг солонго” элс хайрганы уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

15.Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт №10

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэрэгжилт /Бүрэн хэрэгжсэн, Тогтмол хэрэгжиж байгаа, Төлөвлөж байгаа/	Хэрэгжилт
1	Цаг агаарын гэнэтийн үзэгдлээс үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Цаг агаарын улирлын, сарын, 7 хоногийн, өдөр тутмын урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд тогтмол ашиглах	“Очирням” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Цаг агаарын мэдээг 7 хоног бүр гарган нийт ажилчдад танилцуулан, арга хэмжээг авч ажилласан.
2	Гал түймрийн улмаас үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	“Очирням” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Хийгээгүй
3		Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах	“Очирням” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн.	Шаардлагатай цэгүүдэд галын хор, санамж бичиг галын сарааг байршуулсан.
4	Газар хөдлөлт, чичирхийллийн улмаас	Болзошгүй ослын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	“Очирням” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Ажил эхлэхийн өмнө нийт ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч ажиллаж байна. АА-ны зөрчилгүй ажилласан.
6		Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	“Очирням” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Нийт ажилчдад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг хуваарилан өгч, шаардлагатай нэг бүрийг хэрэгслийг өгч ажилласан.
7	үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд тогтмол хяналт тавьж, засвар үйлчилгээг тогтмол хийж байх	“Очирням” ХХК-ний ажилчид	Бүрэн хэрэгжсэн	Тогтмол хяналт тавьж ажилласан. 2024 онд гаргасан зөрчилгүй.

Шаардлагатай цэгүүдэд галын хор, санамж бичиг

галын сарааг байршуулсан байдал

ГАЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ САМБАР
ГАЛ УНТРААХ АНГИ c 101

ГАЛЫН ТӨРЛҮҮД

ГАЛ ТҮЙМРИЙН ШАЛТГААН

ГАЛААС ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

ГАЛ ГАРАХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Галын тоног төхөөрөмж

ГАЛ УНТРААГУУРЫН БҮТЭЦ

ТҮГЭЭМЭЛ АШИГЛАГДАГ ГАЛ УНТРААГУУРУУД

Хэрхэн ажиллуулах вэ?

Хэрхэн шалгах вэ?

ХУУЛЬ ЭРХ ЭҮЙ

ГАЛЫН АЮУЛГАА ТАСАРХААС ХАМГААЛАХ

Утас: 976-11-305940, факс: 70181877

Самбар доторхуйн Галын тоног төхөөрөмж, Гал унтраагуур, Гал унтраагуурын бүтэц, Түгээмэл ашиглагддаг гал унтраагуурууд, Хэрхэн ажиллуулах вэ?, Хэрхэн шалгах вэ?, Хууль эрх зүй, Галын аюулгаа тасархаас хамгаалах.



16. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт

Төслийг хэрэгжүүлсэн явцад байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тухайн орчинд зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, холбогдон гарах зарим зардлуудын хамт тодорхойлж ирсэн.

Төслийг хэрэгжүүлэхэд баримтлан ажиллах ОХШХ нь тус төсөл хэрэгжих орчны байгалийн болон нийгэм эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааг ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичгийн нэг юм.

Төслийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны явцад хяналт шинжилгээний ажлыг энд тусгасан хугацаа болон аргачлалын дагуу үргэлжлүүлэн хийх нь тухайн төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг шуурхай тогтоохоос гадна түүний олон жилийн судалгааны мэдээ материал нь нутгийн хөрс, ургамал, гадаргын ба газрын доорх ус зэрэг экосистемийн бүрдэл хэсгүүдийн хоорондын харилцан шүтэлцээг тодорхойлж, тэдгээрийн талаарх шинжлэх ухааны мэдлэгийг бий болгох чухал хэрэглэгдэхүүн болно.

Жил бүр хийгдсэн хяналт, шинжилгээний үзүүлэлтүүдийг анхааралтай судалж үзэж байх нь цаашдаа байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчин болон тухайн нутагт оршин суугчдыг төслийн нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг илүү үндэслэлтэй болгох юм. Нөгөө талаас ОХШХ-г улам боловсронгуй болгох хяналт, шинжилгээ хийж байгаа объектоо бүрэн хамарч байгаа эсэхийг хянахад чухал ач холбогдолтой байх болно.

Агаарын тоосжилт харьцангуй багассан. Агаар, ус, хөрсний шинжилгээг БОХЗТЛабораторид хийлгэсэн.

**“Бөхөг солонго” элс хайрганы уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

Хүснэгт №11

Хяналт	А.	Б.	В.	Г.
шинжилгээний дээж	Дээж авах цэгийн тоо	Дээж авах цэгийн байршил	Давтамж	Төсөв /мян.төг/
Хөрс	2	Карьер орчимд,	Жилд 1 удаа	113.5
Агаар	1	Карьер орчимд,	Жилд 1 удаа	49.5
Нийт				163.0

17. ДҮГНЭЛТ

Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний тухайн жилийн төсөв, биелэлтийг Хүснэгт №12-д үзүүлэв.

Хүснэгт №12

д/д	Мэдээллийн төрөл	мян. төг биелэлт	тайлбар
1	Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	36482.07	
2	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	600.0	
3	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	1500.0	
4	Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /техник/	15297.07	
5	Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв /биологи/	2750.0	
6	Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний төсөв	14822.0	Зардал гаргаагүй
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	-	Зардал гаргаагүй
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	650.0	
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	163.0	
10	Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	-	хамааралгүй
11	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төсөв	700.0	

**“Бөхөг солонго” элс хайрганы уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний биелэлтийн тайлан**

2024 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн солбицол: (WGS-84,UTM тусгагд)

Д.д	Х	У	В	Л
1	5288810.2105	618524.9052	47 44 30.37	106 34 51.76
2	5288835.8195	618520.1864	47 44 31.20	106 34 51.56
3	5288896.2255	618555.4849	47 44 33.13	106 34 53.32
4	5288895.7070	618631.0572	47 44 33.07	106 34 56.94
5	5288864.9370	618663.3197	47 44 32.05	106 34 58.46
6	5288602.9440	618774.2032	47 44 23.49	106 35 03.53
7	5288689.0487	618808.5349	47 44 26.26	106 35 05.26
8	5288677.2584	618827.8465	47 44 25.86	106 35 06.17
9	5288588.9967	618824.0851	47 44 23.01	106 35 05.91
10	5288573.7744	618808.4154	47 44 22.53	106 35 05.14

2024 онд биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн солбицол: (WGS-84,UTM тусгагд)

Д.д	Х	У	В	Л
1	5288899.1930	618516.2224	47 44 33.26	106 34 51.43
2	5288924.6278	618623.9489	47 44 34.01	106 34 56.63
3	5288900.8774	618630.8364	47 44 33.23	106 34 56.94
4	5288872.2154	618518.8535	47 44 32.38	106 34 51.53

2024 онд олборлот явуулсан талбайн солбицол: (WGS-84,UTM тусгагд)

Д.д	Х	У	В	Л
1	5288772.6663	618541.8423	47 44 29.14	106 34 52.54
2	5288617.3164	618620.4276	47 44 24.06	106 34 56.16
3	5288591.8446	618728.6834	47 44 23.16	106 35 01.33
4	5288548.9688	618752.7039	47 44 21.76	106 35 02.44
5	5288518.2685	618724.1693	47 44 20.78	106 35 01.04
6	5288610.3779	618660.1788	47 44 23.81	106 34 58.06
7	5288602.1094	618553.0814	47 44 23.61	106 34 52.91

БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗУРАГ



БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗУРАГ



БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗУРАГ



“Бөхөг солонго” элс хайрганы уурхайн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

НХМаягт БМ-3

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

“МОНХИЙН ТӨРӨВСӨГ УУРХАЙН” **“ОЧИРНЯМ” ХХК**
 (Байгууллагын нэр) (Худалдан авагчийн нэр)

ЗАРЛАГЫН БАРИМТ №

Регистрийн № [] [] [] [] [] [] Регистрийн № [] [] [] [] [] []

20 24 он 10 сар 21 өдөр (Тээвэрлэгчийн хаяг, албан тушаал, нэр)

№	Материал үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар	КОД	Хэм-жих нэгж	Тоо хэмжээ		
				тоо	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	логны чим			500	3000	1,500,000
2	зэс					
3	бууц					
4	төрсөлт			2500	5000	12,500,000
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						
13						
14						
15						
16						
17						
18						
19						
20	Дүн					14,000,000

Хүлээлгэн өгсөн эд хариуцагч: Цэцэгбаяр

Хүлээн авагч: Очирын

Хүлээн авсан нягтлан бодогч: Дэлгэрмэл

ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗУРАГ



ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗУРАГ



ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗУРАГ



БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗУРАГ



БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗУРАГ



